



ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

жилийн тайлангийн хурал

**Ард Санхүүгийн Нэгдлийн жилийн тайлангийн хурлын
хөтөлбөр**

2017.01.19

- 10:00 Нээлтийн үйл ажиллагаа
- 10:10 Нээлтийн үг (Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг)
- 10:20 2017 оны Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн тайланг танилцуулах үйл ажиллагаа
 - o 10:20 Ард Лайф (Гүйцэтгэх захирал Ц.Должин)
 - o 10:25 Ард Бит, Ард Менежмент (Гүйцэтгэх захирал Б.Золбоо)
 - o 10:30 Ард Актив ХЗХ (Гүйцэтгэх захирал Г.Билгүүн)
 - o 10:35 Ард Секюритиз ҮЦК (Гүйцэтгэх захирал Ж.Золзаяа)
 - o 10:40 Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК/Жинст Увс ХК(Гүйцэтгэх захирал Б.Тамир)
 - o 10:45 Ард Даатгал (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)
 - o 10:50 Ард Кредит ББСБ (Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг)
 - o 10:55 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Монгол Шуудан ХК (Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал, Монгол Шуудан ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ч.Ганхуяг)
- 11:10 Q&A, Хэвлэлийн бага хурал
- 11:50 Хаалтын үйл ажиллагаа



2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа

Үндсэн үйл ажиллагаа

- Компанийн Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирлага шинээр томилогдов.
- Тэргүүлэгчдийн Зөвлөл 3 удаа хуралдаж, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, компанийн өсөлтийг хэвээр хадгалах хэд хэдэн шийдвэрүүдийг гаргасан.
- Нийт хөрөнгө 1.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 121% өсөв.


Хадгаламж

- Нийт хадгаламжийн хэмжээ 1,107 сая төгрөгт хүрч өмнөх оноос 130 хувиар өсөв.
- 2017 онд шинээр 834 сая төгрөгийн хадгаламж шинээр татав. Нийт хадгаламжийн 75% шинээр татсан хадгаламж эзэлж байна.


Зээл

- Нийт зээлийн үлдэгдэл 787,3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 60% өсөв.
- Шинээр 1,137 сая төгрөгийн зээлийг олгов.


Нийт хөрөнгө




Хадгаламж




Зээл




Гишүүдийн тоо




Хүүгийн орлого



Хүүгийн зардал



Цэвэр ашиг





МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа

ARD BIT **харо**

Биткойны арилжаа, хэтэвч - Ард Бит

Ард Бит нь 2017 оны 9 сард үүсгэн байгуулагдаж, дэлхийн Биткойны анхдагч банк болох Запо (харо.com)-гийн агентаар ажиллаж эхэлсэн бөгөөд 2017 оны 10 сарын 1-ний өдрөөс эх хэлээрээ, өндөр зардал чирэгдэлгүйгээр монгол иргэн бүрд цахим мөнгөний хэтэвч нээж өгөх, Биткойныг дотоодын мөнгөн тэмдэгтээр бэлнээр болон бэлэн бусаар худалдан авах, зарах, улс хооронд шилжүүлэх боломжийг нээсэн. Үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш 3 сарын хугацаанд туршилт хийх журмаар зөвхөн Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигч нарт Биткойн зуучилж, тулгарч байсан эрсдэл, дутагдлыг засан залруулсан. 2017 онд нийтдээ 359 харилцагчидтай болж, 4.15 тэрбум төгрөгийн гүйлгээгээр 155.74 Биткойн харилцагчид даа зуучилсан.



КриптоҮндэстэн хөрөнгө оруулалтын хэрэгсэл

Ард Менежментийн ТУЗ-ийн хурлаар батлагдсан 2018 оны төлөвлөгөөний дагуу криптовалютад хөрөнгө оруулалт хийх сан үүсгэн байгуулах зорилт тавьсан. КриптоҮндэстэн чуулга уулзалтын үр дагавар болон оролцогчдын криптовалютад хөрөнгө оруулалт хийх сонирхол дээр үндэслэн криптовалютын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах зорилтыг түргэвчилж 2017 оны 12 сарын 9-ны өдөр 100 гаруй хөрөнгө оруулагчдыг хамарсан уулзалт зохион байгуулж, 12 сарын 23-ны өдөр хүртэл 3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Сангийн үйл ажиллагааг 2018 оны 1 сарын 11-нд эхэлсэн.



Ард, Шангри-Ла Молл, Улаанбаатар

Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын бүтээгдэхүүнийг борлуулах, нэг цэгт бүх төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор хотын төвийн бүсэд байршилтай Шангри-Ла Моллд салбар нээсэн. Дизайны компани болох Скиннитэй хамтран ажиллаж 3 сарын хугацаанд салбарын дизайныг гаргаж, дотор заслыг гүйцэтгэсэн.



Орлогын тайлан

(мянган төгрөг)	2016.12.31	2017.12.31
Үйлчилгээний орлого	-	60,211.09
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	13,056.87
Хүүний орлого	-	134.16
Бусад орлого	-1	,000.00
Нийт орлого	-	74,402.11
Ерөнхий удирдлагын зардал	5,831.30	87,479.34
Санхүүгийн зардал	-	976.01
Нийт зардал	5,831.30	88,455.35
Татварын өмнөх ашиг	(5,831.30)	(14,053.24)
Татварын зардал	--	
Цэвэр ашиг (алдагдал)	(5,831.30)	(14,053.24)
ХО-ын үнэ цэнийн өсөлт	-	91,781.13
Хойшлогдсон татварын зардал	-9	,178.11
Орлогын нийт дүн	(5,831.30)	68,549.78

Санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөг)	2016.12.31	2017.12.31
Бэлэн мөнгө	33.30	5,523.00
Авлага	99,000.00	3,681.12
Урьдчилж төлсөн зардал	58.00	304.50
Үндсэн хөрөнгө	-1	,020.74
Урт хугацаат ХО	312,500.00	452,900.00
Нийт хөрөнгө	411,591.30	463,429.36
Дансны өглөг	18,005.41	302,105.49
Цалингийн өглөг	256.60	-
Татварын өглөг	302.29	568.97
Хойшлогдсон татварын өр	-9	,178.11
Нийт өр төлбөр	18,564.30	311,852.57
Энгийн хувьцаа	400,000.00	100,000.00
ХО-ын бодит үнэ цэнийн тохируулга	-	82,603.02
Хуримтлагдсан алдагдал	(6,973.00)	(31,026.24)
Нийт эздийн өмч	393,027.00	151,576.78
Нийт өр төлбөр ба өмч	411,591.30	463,429.36



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа



- Компанийн дотоод бүтэц 2 удаа өөрчлөгдөв
- ТУЗ 4 удаа хуралдаж, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, дотоод хэд хэдэн шийдвэрүүдийг гаргасан
- 3 төгрөгийн бонд - нийт 4.3 тэрбум төгрөг, 2 долларын бонд - нийт 850 мянган доллар хаалттай хүрээнд гаргаж амжилттай борлуулав
- Степпе-Голдын IPO хийхийн өмнөх хөрөнгө татан төвлөрүүлэлтэд оролцсон
- Ард Академи ТББ-ээрээ дамжуулан оны туршид сургалт, семинаруудыг зохион байгуулав
- Ардын брокер аянг эхлүүлж Ард Даатгал, Монгол Шуудангийн салбаруудын 56 хүнийг ажиллуулах гэж байна.
- Эрдэнэт, Чойр, Сайншанд, Замын-Үүд, Хэнтий, Багануур хотуудын 1,338 хүн хөрөнгийн зах зээлийн тухай танилцуулга хийсэн
- Жинст Увс ХК, Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн нэгтгэлийн ажил амжилттай явагдсан
- Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулсан



СЕКЮРИТИЗ
ҮЦК

БОНД

Төгрөгийн бонд

Ард Санхүүгийн Нэгдэл 2,200,000,000

Ард Кредит 1,738,000,000

Эн Эй Пи 350,000,000

Долларын бонд

Ард Санхүүгийн Нэгдэл 250,000

Хүннү бонд 600,000



САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ



NATIONAL
ARCHITECTURAL PROJECT
N.A.P GROUP



HUNNU AIR




КРЕДИТ
ББСБ


Хүчтэй. Хамтдаа




Харилцагчдын тоо




Нийт орлого




Нийт зардал




Дэлгэрэнгүй ашиг




МХБ-ийн арилжаа




Ард Санхүүгийн Нэгдэл
хувьцааны арилжаа




Долларын бонд



Төгрөгийн бонд



ЗГҮЦ





ЛАЙФ
КОМПАНИ


2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа




- МТНД-с нэрээ сольж Ард Лайф болов.
- Ард Санхүүгийн Нэгдэл ₮1 тэрбум хөрөнгө оруулалт хийв.
- Голомт кастодиантай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөрөнгөө хадгалуулж эхлэв.
- Шинээр 11 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, харилцагчдын тоо 163 хувиар өсч 870-д хүрэв.
- Нийт тэтгэврийн хуримтлалын хэмжээ өмнөх оныхоос 113 хувиар өсч ₮490.2 саяд хүрэв.
- Ард Даатгалтай хамтран эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүнтэй хослуулан борлуулж эхлэв.
- Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хуулийн төслийн багтай хамтран ажиллаж эхлэв.
- 2018 онд хамтран ажиллахаар хэд хэдэн компанитай хэлцэл хийв.


**Тэтгэврийн сангийн
хөрөнгө**




Мөнгөн хөрөнгө



**Урт хугацаат хөрөнгө
оруулалт**




**Тэтгэврийн
хуримтлал**






Хувь нийлүүлсэн хөрөнгө




+10,000%

Хуримтлагдсан ашиг



+309%

Орлого



+239%

Зардал



+399%

Ашиг



+131%




ДААТГАЛ
SINCE 1994

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа




НИЙТ
ХӨРӨНГӨ



+23.0%

НИЙТ
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ




+35.6%



ДААТГАЛ
SINCE 1994


ОРЛОГО

ХУРААМЖИЙН
ОРЛОГО



+44.4%

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЛОГО



+74.6%


Хүчтэй. Хамтдаа



ДААТГАЛ
SINCE 1994


ДААТГАЛЫН ЗАРДАЛ

НӨХӨН ТӨЛБӨР



+56.5%

ДАВХАР ДААТГАЛ



+145.2%


Хүчтэй. Хамтдаа



ДААТГАЛ
SINCE 1994


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ БОЛОН АШИГТ АЖИЛЛАГАА

ЗАРДАЛ



+1.5%

ЦЭВЭР АШИГ



+144.9%

Харьцаа үзүүлэлт	2015	2016	2017	Өөрчлөлт	
				дүн	хувь
Зардлын харьцаа	0.44	0.40	0.33	(0.07)	-17.5%
Хохирлын харьцаа	0.44	0.27	0.35	0.07	27.2%
Ашгийн харьцаа	(0.02)	0.05	0.09	0.04	99.0%
ROA	-1.6%	4.7%	9.9%	5.21%	110.6%
ROE	-3.4%	10.7%	22.4%	11.73%	109.5%

Компани нэг төгрөгний орлого олохийн тулд 0.33 төгрөгний зардал гаргаж байгаа нь өмнөх жилүүдээс буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд компанийн үр ашиг нэмэгдэж байгаа илэрхийлж байна.


Хохирлын харьцааны хувьд өмнөх 2016 оноос өссөн харагдаж байгаа ч нийт олгосон нөхөн төлбөрийн 1.5 тэрбум төгрөг нь давхар даатгалаас төлөгдсөн бөгөөд даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр нь 2.5 тэрбум төгрөг буюу компанийн хариуцаж төлсөн нөхөн төлбөрийн харьцаа 0.24 гарсан байна.

Компанийн 10.27 хувийг эзэмшигч Блью Планет ХХК болон 2.01 хувийг эзэмшигч Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-иуд өөрсдийн эзэмшлийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д худалдсан. Дээрх арилжааны үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Ард Даатгалын 95.31 хувийг эзэмших боллоо.



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН**

Хөдөө аж ахуйн давхар даатгалын компанитай хамтран газар тариалангийн даатгал, малын индексжүүлсэн даатгалуудыг улсын хэмжээнд хийсэн.



Биткойн болон бусад криптовалютатад хөрөнгө оруулалт хийж ашигтай ажилласан байна.



2016 оны цэвэр ашигаас **30% буюу 129 сая** төгрөгийн ногдол ашиг олгосон байна.



Хүчтэй. Хамтдаа



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН
НЭРЭМЖИТ ЧИНГЭЛТЭЙ ХАЙРХАНЫ ХИШИГ
БАРИЛДААН**



**МОНГОЛ
ШУУДАН**

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа



Орчин үеийн шуудангийн салбаруудын өнгө төрхийг тодорхойлох зорилгоор шуудангийн үйлчилгээний **ЖИШИГ** салбар байгуулан, шуудангийн салбаруудад мөрдөгдөх үйлчилгээний стандартыг боловсруулан туршив..



Үйлчилгээний төрөлжилтийг бий болгох, орлогын шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор **POSTSHOP** төслийн ажлыг **Төв шуудан, Жишиг** салбаруудад эхлүүлэв.



АТҮТ-тэй хамтран “Сонгино хайрхан” АТТ буюу Драгон төвд шуудангийн ачаа тээвэр, тээш хадгалалтын төвийг байгуулж, зорчигч тээврийн автобусаар явдаг дайвар ачааг нэгдсэн журамд оруулж, **ТЭЭШ** илгээх хадгалах үйлчилгээг эхлүүллээ. Энэ ажлын хүрээнд Дархан, Говь-Алтай зэрэг аймагт хэрэгжүүлж эхэллээ.



Хэвлэл захиалгыг боловсронгуй болгох, бодит өртгийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор **POSTNEWS.MN** сайтыг ашиглалтанд оруулав.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ШИНЭ ЭХ ҮҮСВЭР БИЙ БОЛГОХ



Улаанбаатар хотын А төвийн бүс, шуудангийн хэрэглэгчдийн болон хүн төвлөрсөн бүсийн шуудан, илгээмжийн хүргэлтийг хурдан болгох, хотын шинэ төвлөрлийн бүсүүдэд салбарын үйл ажиллагааг зохион байгуулж, А бүсийн хүргэлтийн ажлыг эхлүүлэв.



Ребрандингийн төлөвлөгөөний дагуу компанийн шинэ өнгө төрхийг бий болгох, Брэндбүүк боловсруулан батлуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүллээ.



Үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 178 байгууллагатай шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, хамтран ажиллах санамж бичиг шинээр байгуулав.




Буухиа шуудангийн орлого солилцоог нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор **Буухиа шуудан** солилцдог улс орныг 116 болгон нэмэгдүүллээ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



Ажилчидын ажлын ачааллыг жигдрүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цалин урамшууллын системийг тодорхой болгох зорилгоор Ажилтаны гүйцэтгэлийн үнэлгээний журмыг боловсруулан KPI системийг нэвтрүүлж, туршив.



Нээлтэй, бизнесийн компанийн хувьд шинэ ажилтан шалгаруулж авах, мэргэжил ур чадвар, мэдлэгийг харгалзан шалгаруулалт хийх зорилгоор **сонгон шалгаруулалтын журам** боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.



Компанийн үйл ажиллагааг сайжруулах, **ХАРИЛЦАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ, САЛБАРЫН ТОХИЖИЛТ- ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ**-уудыг боловсруулан батлав.




Үйл ажиллагааг боловсронгуй болгох, санхүүгийн сахилга батыг сайжруулах үүднээс **Кассын програм хангамжийг** Улаанбаатар хотын салбаруудад суурилуулан туршив. Мөн аймгийн ШҮГ-уудад суурилуулан хэрэгжүүлж эхэллээ.

Хаалтын ханш



Арилжигдсан ширхэг



Нээлтийн ханш: 315 төгрөг
Хаалтын ханш: 552.5 төгрөг
Өсөлт: 75.4 хувь



КРЕДИТ
ББСБ

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа

Бүх бизнесийн
зээлийн хүү

2.0% - 2.3%

Бизнесийн зээлийн хүүгээ 2-2.3 хувь болгон бууруулж “Хамгийн бага хүүтэй ББСБ” болон ажиллаж эхэлсэн бөгөөд бизнесийн зээл олголтоо идэвхжүүлсэн.



Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж 2016 оны тайланг батлан тухайн жилийн ашгийн **50 хувь буюу 200 сая** ногдол ашгаар хуваарилах шийдвэр гаргасан.




Санхүүгийн зохицуулах хорооноос богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрлийг нэмж авсан.



Нийгмийн хариуцлага ажлын хүрээнд 1000 цүнх challenge арга хэмжээнд оролцон 29-р сургуулийн сурагчдад хичээлийн хэрэгсэл бэлэг болгон гардуулж өгөв.



Лизингийн зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсэн



Кредит картын бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж нийт 598 харилцагчтай болсон бөгөөд онлайнаар зээлийн өргөдөл хүлээн авдаг боллоо.



2017 оны 4 дүгээр 13-ны ТУЗ-ийн хурлаар гарсан шийдвэрийн дагуу хаалттай бонд гаргаж 1.6 тэрбум төгрөгийн бондыг амжилттай татан төвлөрүүлсэн.




Грэйпсити-тэй стратегийн түвшинд хамтран ажиллах болсон бөгөөд Смарт үндсэн банкны систем болон Мостмони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээг байгуулан системийн нэвтрүүлэлт эхэлсэн.




КРЕДИТ
ББСБ

2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ХӨРӨНГӨ




САНХҮҮЖИЛТ




ЗЭЭЛИЙН БАГЦ




НИЙТ ХУГАЦАА ХЭТРЭЛТ



ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ХҮҮ



ЦЭВЭР АШИГ



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨӨЖ





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

2017 оны тайлан

Хүчтэй. Хамтдаа

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН 2 НАС ХҮРЛЭЭ!


Нийт **900+** хувьцаа эзэмшигчид

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө **1.8 тэрбум** төгрөг

Хөрөнгө оруулалтын хэрэгжсэн + хэрэгжээгүй олз нийт **0.9 тэрбум** төгрөг

Дотоод үнэлгээ **2.6 тэрбум** төгрөг

Нэгж хувьцааны дотоод үнэлгээ **1,611.89** төгрөг



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН НЭЭЛТТЭЙ ХК БОЛЛОО!

Монголд анх удаагаа Монголын
Хөрөнгийн Бирж дээр
бүртгэлтэй Жинст Увс ХК-д
урвуу нэгдэл хийн нээлттэй ХК
боллоо

Нэгж хувьцааны анхны үнэ
1,000 төгрөг

МХБирж дээрх үнэ **1,858**
төгрөг (2017.12.31-ний
байдлаарх хаалтын ханш)

Дотоод үнэлгээ **2.6** тэрбум
төгрөг

2 жилд **85.8** хувийн өсөлт



Хаалтын ханш



Арилжигдсан ширхэг



Нээлтийн ханш: 500 төгрөг* (1,000 төгрөг**)

Хаалтын ханш: 1,858 төгрөг

Өсөлт: 272 хувь (85.6 хувь)

* Жинст Увс ХК-ийн нэгдлийн өмнөх сүүлийн хаалтын ханш

**Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн нэгж хувьцааны анхны үнэ



4 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Хөрөнгө Оруулагч Үндэстэн (Жинст Увс) ХК-ийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-тай нэгдэх асуудлыг хэлэлцэнэ



Үр дүнд, Монголын Хөрөнгийн Бирж дээр Монголын анхны дэвшилтэд технологи дээр суурилсан банк, санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьцаа **ARD** нэртэй гарах болно

САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

2017 оны онцлох үйл явдал

Хүчтэй. Хамтдаа



Нийт хөрөнгө **39.4** ➔ **49.6** тэрбум төгрөг



Стратегийн буюу урт хугацаат хөрөнгө оруулалтын багц **25.6** ➔ **38.8** тэрбум төгрөг, өсөлт **51.6** хувь



Өөрийн хөрөнгө **37.4** ➔ **43.1** тэрбум төгрөг, өсөлт **15.1** хувь



Нэгж хувьцааны дотоод үнэлгээ **2,454** ➔ **2,900** төгрөг, өсөлт **18.2** хувь



Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц нийт **7.1** тэрбум төгрөгөөр буурав



Цэвэр авлага нийт **2.6** тэрбум төгрөгөөр өсөв



Нийт **3,382,924** ширхэг хувьцааны арилжаа явуулсны дотор **1.4** саяыг нь худалдаж, **2** сая ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авсан



Хувьцааны дотоод арилжааны жигнэсэн дундаж үнэ 2017 онд **1,886** төгрөг ➔ оны сүүлээр жижиглэнгийн арилжааны үнэ **2,500** төгрөг



2018 оны эхнээс **2,900** төгрөгөөр арилжаалж эхэлсэн



Нийт зарласан хувьцаа **17.2 сая**, эргэлтэнд байгаа хувьцаа **14.15** ➔ **14.96** сая



Монгол Шуудан ХК-д Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшиж буй хувь **16.1** тэрбум төгрөг, стратегийн багцын **41.4** хувь




Ард Даатгал ХХК үнэлгээ **7.7** ➔ **9.3** тэрбум төгрөг, өсөлт **20.6** хувь, стратегийн багцын **23.9** хувь

Ард Даатгал дахь хувиа нэмэгдүүлж, 95 хувийг нь эзэмших болов. Ард Даатгалын захирлаар Г.Цогбадрах томилогдов



Ард Кредит ББСБ үнэлгээний өсөлт **19.4** хувь, стратегийн багцын **11.8** хувь



Техник Технологийн Дээд Сургуульд эзэмшиж байсан **50** хувиа худалдсан, оны эцэст дахин хөрөнгө оруулах шийдвэрийг гаргав (**12.41** хувь)



КриптоҮндэстэн хөрөнгө оруулалтын тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулагдав




КриптоҮндэстэн санд нийт 950 сая төгрөг хөрөнгө оруулав



153 хөрөнгө оруулагч




КриптоҮндэстэн блокчэйн олборлолт болон криптовалютын сагсанд хөрөнгө оруулах зорилготой ажиллаж эхэллээ





- ① Нийт олгосон урамшуулал **1 бүхэл биткойн, 2 биткойн кэш, 7 этэриум – 23,151 ам.доллар буюу 56,120,108 төгрөг**
- ① Хамрагдсан хүний тоо **305** хүн
- ① **14** азтан
- ① **1** бүхэл биткойн буюу **28,880,748** төгрөг бүхий бэлэгний хуваалтанд орох **568** хувьцаа эзэмшигч тус бүр **50,846** төгрөг бүхий биткойн хүртэнэ







**Анхаарал тавьсанд
баярлалаа**



Асуулт, хариулт

Хүчтэй. Хамтдаа